Хураангуй. Монгол орны нэн ховор, ховор 6 зүйл эмийн ургамлаас эндофит бактерийн 41 өсгөвөр ялган авсан. Эдгээр өсгөврүүдээс 10 өсгөвөр индол цууны хүчил (ИЦХ) нийлэгжүүлж, 8 өсгөвөр фосфат, 3 өсгөвөр цайрыг уусгах чадвартай байв. ИЦХ нийлэгжүүлж, фосфат болон цайр уусгах чадвартай байсан өсгөврүүдээс Урал чихэр өвсний үндэснээс ялгасан P23-R2, Зүүн гарын гоёоны газрын дээд хэсгээс ялган авсан P26-H1 дугаартай өсгөврүүд нь ИЦХ нийлэгжүүлэхээс гадна фосфат уусгах чадвартай байна. Мөн Төвд ланцайны цэцэг болон навчнаас ялгасан P31-F1, P31-L1 өсгөврүүд нь фосфат болон цайрыг уусгах чадвартай байв. Цаашид нийт ялган авсан өсгөврүүдийн антагонист идэвхийг тогтооход *E. coli*-ийн эсрэг 1, *S. aureus*-ийн эсрэг 1, *B. subtilis*-ийн эсрэг 2, *C. albicans*-ийн эсрэг 3, *A. niger*-ийн эсрэг 1 өсгөвөр идэвхтэй байв. Тэдгээрээс Зүүнгарын гоёоны газрын дээд хэсгээс ялган авсан P26-H5 өсгөвөр нь *E. coli* (18.5 мм), *C. albicans* (10.5 мм), *A. niger* (20.2 мм)-ийн эсрэг идэвхтэй байна. ИЦХ нийлэгжүүлж, фосфат, цайр уусгах, чадвартайгаас гадна антагонист идэвхтэй 23 өсгөврийн ангилалзүйн хамаарлыг молекул маркер ашиглан тогтооход *Acinetobacter*, *Alcaligenes*, *Bacillus*, *Klebsiella*, *Paenibacillus*, *Peribacillus*, *Pseudomonas*, *Serratia*, болон *Terribacillus* зэрэг нийт 9 өөр өөр төрөлд хамаарагдаж байна. *Klebsiella* sp. P26-H1 өсгөвөр нь хамгийн их буюу 28.14 – 68.02 мкг/мл ИЦХ нийлэгжүүлж байгаа нь цаашид газар тариалангийн ургамлын өсөлтийг дэмжихэд ашиглах боломж буйг харуулж байна.

Түлхүүр үгс: эндофит бактери, тодорхойлох, нэн ховор, ховор эмийн ургамал, индол цууны хүчил, антагонист идэвх

Хүлээн авсан 2023.07.31; хянан тохиолдуулсан 2023.12.04; зөвшөөрсөн 2023.12.18

© 2023 Зохиогчид. [CC BY-NC 4.0 лиценз](https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/).

Оршил

Эндофит бактери ургамлын эрхтэнцэрийн эд, эс дотор байршин өсөж үржин, хүрээлэн буй орчны хэвийн болон эрс тэс нөхцөлд эзэн ургамлын өсөлтийг шууд болон шууд бус замаар дэмждэг ургамалд ашигтай бактери юм. Шууд замаар дэмжих нь хэвийн болон стресстэй нөхцөлд ургамлын өсөлттэй холбоотой гормонуудыг зохицуулах эсвэл ургамлын шим тэжээлийн хүртээмжийг шууд нэмэгдүүлэхийг хэлнэ. Шууд бус гэдэг нь антибиотик болон янз бүрийн фермент нийлэгжүүлэн ургамалд өвчин үүсгэгчийн өсөлтийг дарангуйлан ургамлын дархлааг сайжруулдаг [1]. Эндофитууд цайрыг эрдэсжүүлэх, хүхрийг исэлдүүлэх, фосфор, калийг уусгах чадвартайгаас гадна цөөн тооны эндофитууд агаарын азотыг ашиглах чадвартай байдаг [2]. Иймд

ургамлын өсөлтийг дэмждэг эндофит бактерийг биобордоо болгон ашигласнаар хөрсний хэв шинжийг тогтвортой хадгалахад дэм болдог. Энэ нь цаашид тогтвортой хөдөө аж ахуйг хөгжүүлэхэд химийн бордооны оронд ашиглаж болох байгальд ээлтэй, зардал багатай, илүү ирээдүйтэй хувилбар болох юм. Тиймээс эндофит бактерийн судалгаа нэн чухал байна [3]. Манай оронд эндофит бичил биетний судалгаа анх 2009 онд хийгдэж, Монгол орны 14 зүйл эмийн ургамлаас ялгасан эндофит мөөгөнцрийн 83 өсгөврийн 73.5% нь антагонист идэвхтэй болохыг тогтоосон байна [4]. Цаашид Ж.Энх-Амгалан болон бусад судлаачид өөр хэд хэдэн зүйл эмийн ургамлаас эндофит мөөгөнцрийн өсгөвөр ялган тодорхойлж, тэдгээрийн антагонист болон ферментийн идэвх, ургамлын өсөлтийг дэмжих чадвар, алкалоидын нийлэгжлийг тогтоох зэрэг

ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна [5]. Монгол орны нэн ховор болон ховор эмийн ургамлуудаас эндофит бактерийн өсгөвөр ялган авч, антагонист идэвх, ургамлын өсөлтөд нэн шаардлагатай гормон болох ИЦХ-ийг нийлэгжүүлэх, фосфат болон цайр уусгалт зэрэг шинж чанаруудыг тодорхойлж, ангилалзүйн хамаарлыг тогтооход энэхүү судалгааны ажлын зорилго оршино.

Судалгааны материал ба арга зүй

Эндофит бактерийн цэвэр өсгөвөр ялган, ашигт шинж чанаруудыг тодорхойлох

Эгэл өмхий өвс (*Peganum harmala* L.), Төвд ланцай (*Lancea tibetica* Hook.f. & Thomson) 2 зүйл нэн ховор, Зүүнгарын гоёо (*Cynomorium songaricum* Rupr.), Пржевальскийн зээргэнэ (*Ephedra przewalskii* Stapf.), Урал чихэр өвс (*Glycyrrhiza uralensis* Fisch. ex DC.), Ягаан цээнэ (*Paeonia anomala* L.) 4 зүйл ховор ургамал, нийт 6 зүйл ургамлыг судалгааны материал болгон ашиглалаа.

Дээж ургамлын үндэс, иш, навч, цэцэг зэрэг хэсгүүдийг 70% - ийн этилийн спиртээр 1-2 мин, 3% - ийн натрийн гипохлоридоор 3-5 мин, 70% - ийн этилийн спиртээр дахин 0.5-1 мин ариутган, хатаасны дараа 0.5 x 0.5 см зүсч дотор эдийг ил гаргаад циклогексамид антибиотиктой LB агар (казейн пептон 10.0г/л, дрожжийн ханд 5.0г/л, NaCl 10,0г/л, агар 20г/л) хатуу орчин дээр суулгаж 28°C ба 37°C-д 1-7 хоног өсгөвөрлөн эндофит бактерийн цэвэр өсгөвөр ялган авна [4]. Ялгаж авсан нийт өсгөвөрийг *Staphylococcus aureus*, *Bacillus subtilis*, *Escherichia coli*, *Candida albicans*, *Aspergillus niger* зэрэг тест организмын эсрэг антагонист идэвхийг тогтооно. McFarland 0.5 - ын уусмал ашиглан бактерийн тест өсгөвөрийг 5×10^7 эс/мл, дрожжийг 2×10^4 эс/мл, мөөгөнцрийг 2×10^4 эс/мл байхаар тооцож тэжээлт орчинд тарина. Урьдчилан 24 цаг өсгөвөрлөсөн бактерийн өсгөврөөс 6 мм диаметртэй хэрчим зүсч аваад, тест организмтай хатуу тэжээлийн орчны гадаргууд байрлуулж 28°C - т 24 цаг өсгөвөрлөн, өсгөвөрийн эргэн тойронд үүссэн дарангуйллын хүрээг хэмжиж, эерэг хяналттай (канамицин сульфат 25мг/мл, циклогексимид 20мг/мл) харьцуулан антагонист идэвхийг тодорхойлно [6]. ИЦХ үүсэлтийг 0,5% триптофантай болон триптофангүй Nutrient broth шингэн тэжээлийн орчинд өсгөвөрлөн, өсгөвөрийн шингэн дээр Салковскийн урвалж нэмээд сайтар хольж өрөөний температурт харанхуй нөхцөлд 20 мин байлгана. Шингэний өнгө тод улаан болсон нь ИЦХ үүсэлт эерэг гэж үзнэ. Цаашид үүссэн

ИЦХ-ийн хэмжээг спектрофотометрээр 530 нм - т шингээлтийн утгыг хэмжин урьдчилан байгуулсан жиших муруйнаас ИЦХ-ийн хэмжээг бодож гаргана [7]. 0.2% - ийн лецитинтэй Пиковская (глюкоз 10г/л, $\text{Ca}_3(\text{PO}_4)_2$ 2.5г/л, $(\text{NH}_4)_2\text{SO}_4$ 0.5г/л, $\text{MgSO}_4 \cdot 7\text{H}_2\text{O}$ 0.1г/л, NaCl 0.2г/л, KCl 0.2г/л, $\text{FeSO}_4 \cdot 7\text{H}_2\text{O}$ 0.003г/л, $\text{MnSO}_4 \cdot \text{H}_2\text{O}$ 0.003г/л, дрожжийн ханд 0.5г/л, агар 18г/л) тэжээлт орчинд LB агар хатуу тэжээлийн орчинд урьдчилан ургуулсан эндофит бактерийн өсгөвөрийг (хэрчмийн Ø 6 мм) зүсч, 28°C - д 5-7 хоног өсгөвөрлөн, колонийн эргэн тойронд үүссэн хүрээний диаметрийг хэмжиж фосфат уусгах чадварыг тодорхойлно. Цайр уусгалтыг 0.1% - ийн ZnO бүхий орчинд дээрхийн адил тодорхойлно [8,9].

Эндофит бактерийн 16S рРНХ генийн нуклеотидын дарааллыг тогтоон, төрлийн хамаарлыг тодорхойлох: Бактерийн геномын ДНХ-г “Zanaaspeх; Bacterial DNA Extraction Kit” цомог ашиглан зааврын дагуу ялган, 16S рРНХ генийг 9F (5'-GAGTTTGATCCTGGCTCAG-3') болон 1541R (5'-AAGGAGGTGATCCAGCC-3') хос праймер ашиглаж ПГУ - ын аргаар олшруулна. ПГУ-ыг GeneAmp PCR system 9700 (Applied Biosystem) машинд 95°C-д 3 мин, (95°C-д 30 сек, 55°C-д 15 сек, 72°C-д 1 мин) x 30 цикл, 72°C - д 5 мин нөхцөлөөр явуулна ПГУ-ын бүтээгдэхүүнийг “Agarose gel DNA extraction Kit” цомгийг ашиглан цэвэршүүлж, цэвэршүүлсэн бүтээгдэхүүний нуклеотидын дараалалыг БНСУ-ын “Humanizing Genomics Macrogen Inc” компаниар тодорхойлуулав. 16S рРНХ генийн нуклеотидын дарааллаар хамгийн ойр төрөл зүйлийг <https://www.ncbi.nlm.nih.gov>, <https://www.ezbiocloud.net> сайтын мэдээллийн сангаас хайлт хийн ангилал зүйн хамаарлыг тогтоов.

Судалгааны үр дүн

Судалгаанд ашигласан ургамлын дээж авсан газар болон ургамлын мэдээлэл (**1-р хүснэгт**).

Говь-Алтай, Архангай, Төв аймгийн нутаг дэвсгэрээс авсан нэн ховор болон ховор зүйл ургамлын үндэс, иш, навч, цэцэг болон Зүүнгарын гоёо ургамлын газрын дээд, доод, хуучин, шинэ зангилаанаас нийтдээ эндофит бактерийн 41 цэвэр өсгөвөр ялгаж авав (**2-р хүснэгт**).

Зүүнгарын гоёоны шинэ болон хуучин зангилаанаас 6, газрын дээд болон доод хэсгээс 8 өсгөвөр, Урал чихэр өвсний үндэснээс 9, ишнээс 1 өсгөвөр тус тус ялгав. Бусад ургамлын үндэснээс 5, ишнээс 3, навчнаас 7, цэцэгнээс 2 өсгөвөр ялгаж

1-р хүснэгт. Дээж авсан газар болон ургамлын мэдээлэл

| № | Дээж авсан цэг | Дээжийн дугаар | Латин нэр | Монгол нэр |
|---|---|----------------|---|---|
| 1 | Gobi-Altai, Chandmani (N45°34'43" E98°11'38") | P23 | <i>Glycyrrhiza uralensis</i> | Урал чихэр өвс |
| 2 | Gobi-Altai, Chandmani (N45°34'43" E98°13'12") | P26 | <i>Cynomorium songaricum</i> | Зүүн гарын гоёо |
| 3 | Gobi-Altai, Chandmani (N45°34'43" E98°17'50") | P27 | <i>Ephedra przewalskii</i> Stapf ¹ | Пржевальскийн зээргэнэ (хонин зээргэнэ) |
| 4 | Arkhangai, Tsahir (N47°24'52" E101°45'29") | P31 | <i>Lancea tibetica</i> | Төвд ланцай |
| 5 | Tuv, Bayanchandmani (N48°11'23" E106°21'37") | P32 | <i>Paeonia anomala</i> L. | Ягаан цээнэ |
| 6 | Gobi-Altai, Tsogt (N44°95'97" E96°75'66") | P35 | <i>Peganum harmala</i> L. | Эгэл өмхий өвс |

2-р хүснэгт. Нэн ховор болон ховор эмийн ургамлаас ялгасан эндофит бактерийн өсгөвөр

| № | Дээжийн дугаар | Өсгөврийн тоо | Ургамлын эрхтэн, өсгөврийн дугаар | | | |
|---|----------------|---------------|--|----------------------|--|--------------------------------|
| | | | Үндэс | Иш | Цэцэг | Навч |
| 1 | P23 | 10 | P23-R1, P23-R2, P23-R3, P23-R4, P23-R5, P23-R6, P23-R7, P23-R8, P23-R9 | P23-S1 | х | х |
| 2 | P27 | 4 | P27-R1 | P27-S1 | х | P27-L1, P27-L2 |
| 3 | P31 | 4 | P31-R1, P31-R2 | х | P31-F1, P31-F2 | - |
| 4 | P32 | 6 | P32-R1, P32-R2 | х | х | P32-L1, P32-L2, P32-L3, P32-L4 |
| 5 | P35 | 2 | х | P35-S1, P35-S2 | х | - |
| 6 | P26 | 14 | Газрын дээд хэсэг | Газрын доод хэсэг | Шинэ зангилаа | Хуучин зангилаа |
| | | | P26-H1, P26-H2, P26-H3, P26-H4, P26-H5 | P26-R1 P26-R2 P26-R3 | P26-ZN1, P26-ZN2, P26-ZN3, P26-ZN4, P26-ZN5, | P26-ZO1 |

Тайлбар: (х) - дээж материал аваагүй; (-) эндофит бактери илрээгүй

3-р хүснэгт. Эндофит бактерийн антагонист идэвх

| Ургамлын нэр | Өсгөврийн дугаар | Үүссэн дарангуйллын хүрээ, мм (хэрчмийн Ø 6 мм) | | | | |
|------------------------|------------------|---|------------------|--------------------|--------------------|-----------------|
| | | <i>E. coli</i> | <i>S. aureus</i> | <i>B. subtilis</i> | <i>C. albicans</i> | <i>A. niger</i> |
| Урал чихэр өвс | P23-R6 | - | - | - | 20.2±0.7 | - |
| Зүүнгарын гоёо | P26-H5 | 18.0±0.7 | - | - | 10.5±0.8 | 20.2±0.7 |
| | P26-ZN4 | - | 9.0±0.7 | 13.0±0.7 | - | - |
| Пржевальскийн зээргэнэ | P27-R1 | - | - | 11.0±0.7 | 13.5±0.7 | - |

Тайлбар: - идэвхгүй

авав. Дээрх 6 ургамлаас ялгасан эндофит бактерийн өсгөврүүдийн антагонист идэвхийг тогтооход 4 өсгөвөр идэвхтэй байна.

Үүнээс *E. coli*-ийн эсрэг 1, *S. aureus*-ийн эсрэг 1, *B. subtilis*-ийн эсрэг 2, *C. albicans*-ийн эсрэг 3, *A. niger*-ийн эсрэг 1 өсгөвөр идэвхтэй байна. Зүүнгарын гоёоны газрын дээд хэсгээс ялган авсан P26-H5 өсгөвөр нь *E. coli*-ийн эсрэг 18.5 мм, *C. albicans*-ийн эсрэг 10.5 мм, *A. niger*-ийн эсрэг 20.2 мм - ийн хүрээг тус тус

үүсгэж байлаа. Урал чихэр өвсний үндсэнээс ялгасан P23-R6 өсгөвөр зөвхөн *C. albicans* (20.2 мм) - ийн эсрэг идэвхтэй байна. Харин P26-ZN4 дугаартай өсгөвөр *S. aureus* (10.7 мм), *B. subtilis* (13.7 мм) - ийн эсрэг, P27-R1 өсгөвөр *B. subtilis* (11.7 мм), *C. albicans* (13.5 мм) - ийн эсрэг антагонист идэвхтэй байна (**3-р хүснэгт**).

Мөн эдгээр өсгөврүүдийн ИЦХ нийлэгжүүлэх, фосфат болон цайрыг уусгах чадварыг тус тус тогтоосон (**4-р хүснэгт**).

4-р хүснэгт. Индол цууны хүчил нийлэгжүүлэх, фосфат, цайр уусгах чадвартай эндофит бактери

| № | Ургамлын нэр | Өсгөврийн дугаар | | |
|---|------------------------|--|----------------|----------------|
| | | ИЦХ | Фосфат | Цайр |
| 1 | Урал чихэр өвс | P23-R1, P23-R2, P23-R3, P23-R4, P23-R5, P23-R8 | P23-R2, P23-S2 | - |
| 2 | Зүүнгарын гоёо | P26-H1, P26-H3, P26-H4 | P26-H1, P26-R1 | P26-ZO1 |
| 3 | Пржевальскийн зээргэнэ | P27-S2 | P27-L3 | - |
| 4 | Төвд ланцай | - | P31-F1, P31-L1 | P31-F1, P31-L1 |
| 5 | Ягаан цээнэ | - | P32-R2 | - |

Тайлбар: (-) ИЦХ нийлэгжээгүй, фосфат болон цайр уусгаагүй

10 өсгөвөр ИЦХ нийлэгжүүлж, 8 өсгөвөр фосфат, 3 өсгөвөр цайрыг уусгах идэвхитэй байна. Урал чихэр өвснөөс ялгасан 6, Зүүнгарын гоёоноос ялгасан 3, Пржевальскийн зээргэнээс ялгасан 1 өсгөвөр ИЦХ нийлэгжүүлж байв. Урал чихэр өвсний үндэснээс ялгасан P23-R2, Зүүн гарын гоёоны газрын дээд хэсгээс ялган авсан P26-H1 дугаартай өсгөврүүд нь ИЦХ нийлэгжүүлэхээс гадна фосфат уусгах чадвартай байна. Мөн Төвд ланцайны цэцэг болон навчнаас ялгасан P31-F1, P31-L1 өсгөврүүд нь фосфат болон цайрын аль алиныг уусгах чадвартай байна.


Индол цууны хүчил нийлэгжүүлэх чадвартай P26-H1, P23-R5 дугаартай өсгөврүүдийг цаашдын туршилтанд сонгон авав (**1-р зураг**). Эхлээд P26-H1, P23-R5 урьдчилан NB шингэн тэжээлийн орчинд 130 эрг/мин-аар сэгсэрч 24 цаг өсгөвөрлөв. Үүний дараа 1 мл өсгөврийг 100 мл триптофантай болон триптофангүй NB шингэн тэжээлийн орчинд




1-р зураг. Индол цууны хүчил үүсэлт - эерэг өсгөвөр (тод улаан өнгө)

Триптофантай орчинд *Klebsiella* sp. P26-H1 өсгөврийн өсөлтийн динамикийг хэмжихэд эхний 2 өдөр эрчимтэй өсөж, 3 дах өдрөөс өсөлт нь

тогтворжсон бол триптофангүй орчинд 1,5 хоног буюу 36 цагаас огцом өсөж 4 дэх өдрөөс тогтворжиж байна. *Terribacillus* sp. P23-R5 өсгөвөр триптофантай орчинд 2 дах өдөр буюу лог фазаас эсийн өсөлт тогтворжихгүйгээр шууд буурсан. Триптофангүй



2-р зураг. Триптофантай болон триптофангүй орчинд эндофит бактерийн өсгөврийн өсөлтийн динамик



3-р зураг. Триптофантай болон триптофангүй орчинд нийлэгжсэн ИЦХ


орчинд мөн адил 2 дах өдөр буюу лог фазаас эсийн өсөлт тогтворжихгүйгээр шууд буурч байна.

Триптофантай орчинд *Klebsiella* sp. P26-H1 өсгөврийн нийлэгжүүлж буй ИЦХ-ийн хэмжээ нь эхний өдөр 28.1 мкг/мл, 2 дахь өдөр 36.1 мкг/мл, 3 дахь өдөр 44.9 мкг/мл, 4 дэхь өдөр 50.9 мкг/мл, 5 дахь өдөр 56.2 мкг/мл, 6 дахь өдөр 68.2 мкг/мл болон тасралтгүйгээр нэмэгдэж байна. Харин *Terribacillus* sp. P23-R5 өсгөврийн ИЦХ-ийн нийлэгжилт нь эхний өдөр хамгийн өндөр 39.9 мкг/мл байсан ба 2 дах өдрөөс эхлэн буурч 31.95 мкг/мл болсон ба 3, 4, 5, 6 дах өдрүүдэд 27.9 мкг/мл болж тогтмолжин ИЦХ нийлэгжилт зогссон байна. Триптофангүй орчинд *Klebsiella* sp. P26-H1 өсгөвөр нь мөн л ИЦХ-ийг тогтмол нийлэгжүүлж байсан. 1 дэхь өдөр 8.1 мкг/мл, 2 дахь өдөр 15.6 мкг/мл, 3 дахь өдөр 18.8 мкг/мл, 4, 5, 6 дахь өдрүүдэд нийлэгжүүлэх индол цууны хэмжээ (20.2 мкг/мл) өөрчлөгдөөгүй.

Харин *Terribacillus* sp. P23-R5 өсгөврийн ИЦХ-ийн нийлэгжилт нь 1 дэхь өдөр 6.7 мкг/мл, 2 дахь өдөр 14.2 мкг/мл, 3 дахь өдөр 10.6 мкг/мл, 4 дэхь өдөр 10.8 мкг/мл, 5 дахь өдөр 8.7 мкг/мл, 6 дахь өдөр

5-р хүснэгт. Эндофит бактерийн ангилалзүйн хамаарал

| Дээж ургамал | Өсгөврийн дугаар | 16S рРНХ генийн нуклеотидын дарааллаар хамгийн ойр төрөл, зүйл | Төстэй хувь (%) |
|--|------------------|--|-----------------|
| Урал чихэр өвс <i>Glycyrrhiza uralensis</i> Fisch. ex DC. | P23-R1 | <i>Paenibacillus terrae</i> | 99.0 |
| | P23-R3 | <i>Peribacillus frigoritolerans</i> | 100 |
| | P23-R4 | <i>Terribacillus saccharophilus</i> | 99.3 |
| | P23-R5 | <i>Terribacillus saccharophilus</i> | 100 |
| | P23-R6 | <i>Bacillus halotolerans</i> | 100 |
| | P23-R8 | <i>Pseudomonas argentinensis</i> | 100 |
| | P23-S2 | <i>Bacillus halotolerans</i> | 100 |
| Зүүнгарын гоёо <i>Cynomorium songaricum</i> Rupr. | P26-H1 | <i>Klebsiella michiganensis</i> | 99.9 |
| | P26-H5 | <i>Alcaligenes faecalis</i> | 100 |
| | P26-R1 | <i>Serratia ficaria</i> | 99.8 |
| | P26-ZN2 | <i>Bacillus atrophaeus</i> | 100 |
| | P26-ZN4 | <i>Peribacillus frigoritolerans</i> | 100 |
| | P26-ZO1 | <i>Pseudomonas argentinensis</i> | 99.9 |
| Пржевальскийн зээргэнэ <i>Ephedra Przewalskii</i> Stapf. | P27-R1 | <i>Bacillus mojavensis</i> | 99.8 |
| | P27-L3 | <i>Peribacillus frigoritolerans</i> | 99.8 |
| | P27-S2 | <i>Bacillus mojavensis</i> | 99.9 |
| Төвд ланцай <i>Lancea tibetica</i> Hook.f. & Thomson | P31-F2 | <i>Bacillus thuringiensis</i> | 100 |
| Ягаан цээнэ <i>Paeonia anomala</i> L. | P32-R2 | <i>Acinetobacter lwoffii</i> | 98.0 |
| Эгэл өмхий өвс <i>Peganum harmala</i> L. | P35-S2 | <i>Paenibacillus taichungensis</i> | 99.6 |



4-р зураг. Ягаан цээнэ (*Paeonia anomala* L.) -ээс ялган авсан P32-R2 өсгөврийг ойролцоо зүйлтэй харьцуулсан филогенетик мод

хамгийн бага буюу 4.3 мкг/мл болж буурсан.

Эндофит бактерийн өсгөврүүдээс ИЦХ нийлэгжүүлэх, фосфат, цайр уусгах чадвартайгаас гадна антагонист идэвхтэй, колонийн хэв шинж өөр нийт 23 өсгөвөр сонгон авч нуклеотидын дарааллыг тогтоов. Ингэхэд 19 өсгөврийн нуклеотидын дараалал уншигдаж ангилалзүйн хамаарлыг тодорхойлов (**5-р хүснэгт**). Нийт 6 ургамлаас ялган авсан 19 өсгөврийг 16S рРНХ генийн нуклеотидын дараалалд тулгуурлан тодорхойлоход 9 төрөлд хамаарагдаж байна. *Bacillus*-ийн төрөлд 6, *Pseudomonas*-ийн төрөлд 2, *Peribacillus*-ийн төрөлд 3, *Terribacillus*-ийн төрөлд 2, *Paenibacillus*-ийн төрөлд 2, *Acinetobacter*, *Alcaligenes*, *Klebsiella*, *Serratia*-ийн төрөлд тус тус нэг өсгөвөр хамаарагдаж байна. Онцлон хэлэхэд Зүүнгарын гоёоны 6 өсгөвөр нь 6 өөр төрөлд хамаарагдаж байна.

Ягаан цээнээс ялгасан фосфат уусгах чадвартай P32-R2 дугаартай өсгөврийн 16S рРНХ генийн нуклеотидын дарааллаар хамгийн ойр зүйл нь *Acinetobacter lwoffii* (98%) байна. Филогенетик мод байгуулахад P32-R2 дугаартай өсгөвөр *Acinetobacter lwoffii* зүйлтэй нэг төрөлд гэхдээ бие даасан шинэ зүйл болохыг тогтоов (**4-р зураг**).

Хэлэлцүүлэг

Ургамлын өсөлтөд нэн шаардлагатай гормон болох ИЦХ нь триптофанаас хамааралтай, эсвэл хамааралгүйгээр ургамал болон бактерийн эсэд нийлэгжиж байдаг. Бидний ИЦХ-ийн нийлэгжлийг туршсан дүнгээс харахад триптофангүй орчинд өсгөвөрлөсөн өсгөврүүдийн ИЦХ хэмжээ нь триптофантайгаас 2-3 дахин бага байсан (зураг 3). Хэвлэлийн тоймоос харахад *Klebsiella* төрлийн өсгөврийг ИЦХ нийлэгжүүлэх чадвараар *Bacillus*, *Enterobacter* төрлийн өсгөврүүдээс илүү сайн хэмээн тэмдэглэсэн байна [10]. Бохирдсон хөрснөөс ялгасан ИЦХ нийлэгжүүлдэг 18 өсгөвөр дундаас *Klebsiella pneumoniae* AWD5 өсгөвөр глюкоза агуулсан тэжээлийн орчинд хамгийн их буюу 95.31 мкг/мл ИЦХ нийлэгжүүлж байсан байна [11]. Ургамлын өсөлтийг дэмждэг *Bacillus*, *Pseudomonas*, *Paenibacillus*, *Brevibacterium*, *Arthrobacter*, *Enterobacter*, *Stenotrophomonas*, *Chryseobacterium* гэх мэт олон төрлийн эндофит бактери тэмдэглэгдсэн байдаг [12]. Египетийн цөлд ургадаг *Fagonia mollis*, *Achillea fragrantissima* эмийн 2 ургамлаас эндофит бактерийн 13 өсгөвөр ялган авснаас 8 өсгөвөр *Bacillus*, 2 өсгөвөр *Paenibacillus*, 3 өсгөвөр *Brevibacillus* төрөлд хамаарагдаж байсныг тэмдэглэсэн байна [13].

Хятадын Шинжань аймгийн 3 өөр газраас цуглуулсан *Glycyrrhiza uralensis* Fisch. (licorice) ургамлаас нийт 116 өсгөвөр ялган авч ангилал зүйн хамаарлыг нь тогтооход 20 төрөл илэрсэн ба үүний 65% нь *Bacillus* төрлийн бактери эзэлж байсан байна [14]. *Bacillus subtilis* төрлийн бактерийг биохяналт болгон өргөнөөр ашигладаг. Судлаачид эрдэнэ шишийн өвчин үүсгэгч *Fusarium verticillioides* зүйлийн мөөгөнцрийг дарангуйлах шинж чанар бүхий *Bacillus mojavensis* бактерийг олж илрүүлэн, түүнийг биохяналт болгон ашигладаг *Bacillus subtilis* бүлгээс тусгаар, эндофит биохяналтын бүлэг болгон ангилсан байна [15]. Биохяналт болгон ашиглаж байгаа *Bacillus mojavensis*-тэй 99,1% ба 100% төстэй 2 өсгөврийг бид Пржевальскийн зээргэнээс олж илрүүлээд байна. Гадаадын судлаачид *Pennisetum glaucum* үр тарианы ургамлын үндэс болон ойр орчмын хөрснөөс 31 өсгөвөр ялгасан ба 24 нь *Acinetobacter calcoaceticus*, 1 өсгөвөр нь *Acinetobacter baumannii*, 6 өсгөвөр нь *Acinetobacter* sp. тус тус хамаарагдаж, эдгээрээс 26 өсгөвөр фосфат уусгах чадвартай байсан байна [16]. Тарималжуулсан эмийн ургамлаас ялгасан *Alcaligenes* төрлийн эндофит бактери ургамлын үндсэнд өвчин үүсгэдэг *S. rolfsii* мөөгөнцрийн эсрэг идэвхтэйгээс гадна ургамлын өсөлтийг дэмжих чадвартай [17]. Бидний судалгаагаар Зүүнгарын гоёоноос ялгасан *Alcaligenes* төрлийн (P26-H5) өсгөвөр нь *E. coli*, *C. albicans*, *A. niger* зэрэг 3 тест организмын эсрэг идэвхтэй байв.

Дүгнэлт

Монгол орны нэн ховор болон ховор эмийн ургамлаас эндофит бактерийн 41 өсгөвөр ялган авч, 19 өсгөврийг генийн түвшинд тодорхойлон *Bacillus*, *Pseudomonas*, *Peribacillus*, *Terribacillus*, *Paenibacillus*, *Acinetobacter*, *Alcaligenes*, *Klebsiella*, *Serratia* гэсэн 9 өөр төрөлд хамаарагдаж буйг тогтоов. *Klebsiella*, *Alcaligenes* төрлийг Монголд шинээр тэмдэглэв. Мөн антагонист идэвхтэй 4 өсгөвөр, ургамлын өсөлтийн гормон болох ИЦХ нийлэгжүүлэгч 10, фосфат уусгах чадвартай 8, цайр уусгах чадвартай 3 өсгөврийг олж тогтоосон нь цаашид эдгээр өсгөврүүдийг хөдөө аж ахуй газар тариаланд ашиглах бэлдмэл үйлдвэрлэх технологийн судалгааны суурь болох ач холбогдолтой.

Талархал

Энэхүү судалгааг Шинжлэх ухаан технологийн сангийн санхүүжилттэй ШуУз_2020/01 төслийн хүрээнд гүйцэтгэв.

Ашигласан бүтээл

- [1] I. Afzal, Z.K. Shinwari, S. Sikandar, S. Shahzad, Plant beneficial endophytic bacteria: Mechanisms, diversity, host range and genetic determinants. *Microbiological Research.*, 21 pp. 36-49. Apr. 2019 <https://doi.org/10.1016/j.micres.2019.02.001>
- [2] A. Dahiya, R. Kumar, and S. S. Sindhu, Microbial Endophytes: Sustainable Approach for Managing Phosphorus Deficiency in Agricultural Soils. *Endophytes: Mineral nutrient management.*, vol. 3, pp. 3–10. May 2021. https://doi.org/10.1007/978-3-030-65447-4_3
- [3] D.K. Maheshwari. S. Dheeman, Endophytes in Mineral Nutrient Management: Introduction. *Endophytes: Mineral nutrient management.*, vol. 3, pp. 35–75. May 2021. https://doi.org/10.1007/978-3-030-65447-4_1
- [4] J. Enkh-Amgalan, M. Amarbayasgalan, T. Adiyadolgor, Endophytic fungi of Mongolian plants: a promising source for bioprospecting. *Proceedings of the conference: Prosperity of biotechnology and utilization of genetic resources*, 2018.06.08. Ulaanbaatar, pp. 97-104, 2018
- [5] J. Enkh-Amgalan, Isolation and antimicrobial activity of endophytic fungi from medicinal plants in Mongolia. *Proceedings of Institute of Biology, MAS.*, vol. 29, pp. 35-37, 2013
- [6] M. Balouiri, M. Sadiki, S.K. Ibsouda, Methods for in vitro evaluating antimicrobial activity: A review. *Journal of Pharmaceutical Analysis.*, vol. 6, pp. 71-79, Apr. 2016, <https://doi.org/10.1016/j.jpha.2015.11.005>
- [7] SB. Rajini, M. Nandhini, AC. Udayashankar, SR. Niranjana, OS. Lund, HS. Prakash, Diversity, plant growth-promoting traits, and biocontrol potential of fungal endophytes of *Sorghum bicolor*. *Plant Pathol.*, vol. 69, pp. 642–654, Jan. 2020, <https://doi.org/10.1111/ppa.13151>
- [8] P. Vyas, P. Rahi, A. Chauhan, A. Gulati, Phosphate solubilization potential and stress tolerance of *Eupenicillium parvum* from tea soil. *Mycological Research.*, vol. 111, pp. 931-938, Aug. 2007, <https://doi.org/10.1016/j.mycres.2007.06.003>
- [9] C.M. Senthil Kumar, T.K. Jacob, S. Devasahayam, S. Thomas, C. Geethu, Multifarious plant growth promotion by an entomopathogenic fungus *Lecanicillium psalliotae*. *Microbiological Research.*, vol. 207, pp. 153–160, March. 2018, <https://doi.org/10.1016/j.micres.2017.11.017>
- [10] M.A. Mowafy, M.M. Fawzy, A. Gebreil, and A. Elsayed, Endophytic *Bacillus*, *Enterobacter*, and *Klebsiella* enhance the growth and yield of maize. *Soil and plant science.*, vol. 71, pp. 237-246, Feb. 2021, <https://doi.org/10.1080/09064710.2021.1880621>
- [11] J. Rajkumari, L.P. Singha, P.Pandey, Genomic insights of aromatic hydrocarbon degrading *Klebsiella pneumonia* AWD5 with plant growth promoting attributes: a paradigm of soil isolated with elements of biodegradation. *3 Biotech*, Vol. 8, Feb. 2018, <https://doi.org/10.1007/s13205-018-1134-1>
- [12] U.K. Vandana, J. Rajkumari, L.P. Singha, L. Satish, H. Alavilli, P.D.V.N. Sudheer, S. Chauhan, R. Ratnala, V. Satturu, P.B. Mazumder, The Endophytic Microbiome as a Hotspot of Synergistic Interactions, with Prospects of Plant Growth Promotion. *Biology.*, vol. 10, pp. 101, Feb. 2021, <https://doi.org/10.3390/biology10020101>
- [13] M.D.F. ALKhahtani, *et al.*, Isolation and Characterization of Plant Growth Promoting Endophytic Bacteria from Desert Plants and Their Application as Bioinoculants for Sustainable Agriculture, *Agronomy.*, vol. 10, pp. 1325, Sep. 2020, <https://doi.org/10.3390/agronomy10091325>
- [14] L. Li, O.A. A. Mohamad, J. Ma, A.D. Friel, Y. Su, Y. Wang, Z. Musa, Y. Liu, P. Brian Hedlund, L.Wenjun, Synergistic plant–microbe interactions between endophytic bacterial communities and the medicinal plant *Glycyrrhiza uralensis* F, *Antonie van Leeuwenhoek.*, vol. 111, pp. 1735-1748. Oct. 2018, <https://doi.org/10.1007/s10482-018-1062-4>
- [15] W.C. Bacon, M.D. Hinton, R.T. Mitchell, E.M. Snook, B. Olubajo, Characterization of endophytic strains of *Bacillus mojavensis* and their production of surfactin isomers. *Biological Control.*, vol. 62, pp. 1-9, Jul. 2012, <https://doi.org/10.1016/j.biocontrol.2012.03.006>
- [16] F. Rokhbakhsh-Zamin D. Sachdev N. Kazemi-Pour, A. Engineer, KR. Pardesi, S. Zinjarde, PK. Dhakephalkar, BA. Chopade, Characterization of plant-growth-promoting traits of *Acinetobacter* species isolated from rhizosphere of *Pennisetum glaucum.*, *Journal of Microbiology and Biotechnology.* vol. 21(6), pp. 556-66, Jun. 2011, <https://doi.org/10.4014/jmb.1012.12006>
- [17] S. Ray, S. Singh, B.K. Sarma, H.B. Singh, Endophytic *Alcaligenes* isolated from horticultural and medicinal crops promotes growth in Okra (*Abelmoschus esculentus*), *Journal of Plant Growth Regulation.* vol. 35, pp. 401-412, June. 2016, <https://doi.org/10.1007/s00344-015-9548-z>